


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлд:

“ХХ.4. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулахаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх этгээдтэй байгуулах гэрээний төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан)-т даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР